



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 9 дүгээр  
сарын 5-ны өдөр

Дугаар 284

Улаанбаатар  
хот


Улаанбаатар-Дархан чиглэлийн авто  
замын талаар авах зарим арга  
хэмжээний тухай

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Бүс нутгийн замыг хөгжүүлэх, зам засварын төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэх Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам барих ажилд шаардагдах нэмэлт хөрөнгийг уг төслийн II үе шатны санхүүжилтийг урагшлуулах талаар Азийн хөгжлийн банктай хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг хариуцагч Ө.Энхтүвшин, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.

2. Улаанбаатар-Дархан чиглэлд барих авто замын зарим хэсгийг концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх асуудлыг судалж, Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг хариуцагч Ө.Энхтүвшин, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгасугай.

3. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын экспертизээр батлагдсан зураг төсөлд өөрчлөлт оруулахад шаардагдах хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын Шадар сайд,  
Зам, тээврийн хөгжлийн  
сайдын үүргийг хариуцагч

Ө.ЭНХТҮВШИН

Сангийн сайд

Ч.ХҮРЭЛБААТАР